



Эх орончдын нэгдсэн эвслийн 2016 оны 4-р сарын 13-ны өдрийн хурлаар батлав. (Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу хийсэн найруулгын чанартай өөрчлөлтийг 2016 оны 4-р сарын 27-ны өдөр эвслийн Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн батлав)

Эх орончдын нэгдсэн эвсэл (ЭНЭ)-ийн

2016 оны УИХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөр

Эх орончдын нэгдсэн эвсэл (ЭНЭ)-ийн 2016 оны УИХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөр бол монголчуудын сүүлийн 26 жил туулсан зам, алдаа оноо, тулгамдсан асуудлуудлаас сургамж авч Монгол Улс, Монголын төр, Монголын ард түмний язгуур эрх ашигт зохируулан боловсруулсан үндэсний үзэл санаа бүхий Эх оронч бодлого, ухаарал мөн.

МОНГОЛ УЛС
ҮНДЭСНИЙ АУДИТ

УХА0122

№ 78
20 16 он 04 сар

Эгэл эх орончид бид өнөөгийн улс төр, нийгэм, эдийн засгийн хямрал, оюун санааны задрал, байгаль орчны доройтол, шударга ёсны гажуудал, ардчиллын мухардал, сэтгэлгээний ядуурлаас гарахад Монгол Улсад зарчмын цоо шинэ хандлага буюу хувьсгалт эрс шинэчлэл шаардлагатай гэж үзнэ.

Иймээс намчирхалгүй, өргүй, аюулгүй, эрсдэлгүй, авилгагүй Монголоо цогцлоож, мэдлэгт шүтсэн нээлттэй нийгэм байгуулах тухай Эх орончдын мөрийн хөтөлбөрөө өргөн дэвшүүлж байна.

1. НАМЧИРХАЛГҮЙ МОНГОЛ

Төрийн дээр сандайлсан намын бүлэглэл, төрийн албыг өмчилсэн намын гишүүнчлэл, авилгыг үндэслүүлсэн намуудын санхүүжилт, ард олныг талцуулсан намын үзэл суртал, шударга ёсыг алдагдуулсан намын дарангуйллыг устгаж, мэдлэгт суурилсан нээлттэй сайн засаглалыг тогтоож, ард түмнийхээ төрдөө итгэх итгэлийг бид эргүүлэн авчирна.

- 1.1 Хүчтэй Ерөнхийлөгчийн засаглал, хоёр танхимтай парламент бүхий төрийн тогтолцоог дэмжинэ.
- 1.2 Ерөнхий сайдаас бусад танхимын гишүүд парламентийн гишүүн байхыг хориглоно.
- 1.3 Ерөнхий сайдаас бусад Засгийн газрын танхимын гишүүд намаас татгалзсан, мэргэжлийн байх бодлого дэвшүүлнэ.
- 1.4 УИХ-ын гишүүний халдашгүй байдлыг цуцалж, хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байх зарчмыг сэргээж, олонхийн сонгуулиар сонгогдсон гишүүнийг сонгогчдынх нь олонхийн саналаар, хувь тэнцүүлсэн сонгуулиар сонгогдсон гишүүнийг нам нь эргүүлэн татдаг тогтолцоог нэвтрүүлнэ.

- 1.5 Төрийн захиргааны, тусгай, үйлчилгээний албан хаагчдын намын гишүүнчлэл, дэмжигч статусыг хориглож, төрийн албыг улстөрийн хараат байдлаас чөлөөлнө.
- 1.6 Хатуу гишүүнчлэлээр барьцаалах, сум, орон нутагт салбартай байх, хандив, тусламж авах, үл хөдлөх хөрөнгө эзэмших, төрийн албаны үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр хутгалдахыг намуудад хатуу хориглож, мэргэшсэн улстөрчдийн хязгаарлагдмал гишүүнчлэлтэй, дэмжигчдийн ~~статустай~~ статустай, сонгуульд авсан суудлын тоогоор төсвөөс санхүүждэг, улс орны хөгжлийн бодлого боловсруулж улс төрийн сангаас санхүүжүүлдэг институц байхаар хуульчилж, намуудыг татан буулгаж, дахин бүртгэл явуулна.
- 1.7 Төрийн жинхэнэ албыг улстөржүүлж, нөлөөллөө аливаа хэлбэрээр тогтоосон намыг татан буулгана.
- 1.8 Нутгийн өөрөө удирдах ёсыг иргэдийн мэдэлд бүрэн шилжүүлж, бүх шатны Иргэдийн хурлын сонгуулийг намаас ангид явуулах эрх зүйн орчныг үе шаттайгаар бүрдүүлнэ.
- 1.9 УИХ-д суудалтай эрх баригч намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрийн биелэлтэд ээлжит сонгууль зарлахаас 6 сарын өмнө Үндэсний аудитын газраар аудит хийлгэж, сонгогчдод мэдээлнэ.
- 1.10 Бүх шатны шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Үндсэн хуулийн цэц, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Сонгуулийн ерөнхий хороо, Үндэсний аудитын газар, Үндэсний бүртгэл, статистикийн газар, Авилгатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл, Үндэсний олон нийтийн радио, телевизийн дарга нар, Монголбанкны Ерөнхийлөгч, Улсын Ерөнхий прокурорыг улстөрийн намын гишүүн, улстөрч томилохыг хориглож, мэргэжлийн холбоо, олон нийтийн байгууллагаас нэр дэвшүүлж, парламент батламжлахаар хуульчилна.
- 1.11 Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" бодлогын баримт бичигт тусгасан хөгжлийн зорилтуудыг харгалзан Засгийн газрын бүтцийг тогтооно.
- 1.12 Иргэний нийгмийн байгууллагыг төр болон хувийн хэвшлийн нэгэн адил хөгжлийн эрх тэгш гуравдагч тал гэж үзэх бөгөөд үндэсний иргэний нийгмийн байгууллагын тогтолцоо, ажиллах баталгааг бүрдүүлж, ардчилал, хүний эрх, сайн засаглал, тогтвортой хөгжлийн чиглэлээр ажиллах нөөцийг бэхжүүлнэ.
- 1.13 Засгийн газрын тохируулагч агентлаг Үнэ, стандартын хороог байгуулах замаар хэрэглээний үнийн зах зээлийн судалгаа, жишиг үнийг нэгдмэл байдлаар тогтоож, үнийн монополи, тендер, худалдан авалтын луйврыг арилгах, гааль, татварын ажлыг хөнгөвчлөх санаачилга гаргана.
- 1.14 Төрийн улс төрийн албан хаагч, төрийн захиргааны албан хаагч, төрийн тусгай албан хаагч, төрийн үйлчилгээний албан хаагчийн эрх зүйн байдлын тухай багц хуулийг батлан гаргаж, тухайн төрийн алба бүрийн шалгуур

- үзүүлэлт, стандарт, эдлэх эрх, үүрэг, хариуцлага, хангамж, карьерийн зарчмыг нягт тусган хэрэгжүүлэх бөгөөд хуулийн дагуу дахин аттестатчлал явуулна.
- 1.15 Төрийн албаны зөвлөлийн статусыг хараат бус, олон нийтийн байхаар өөрчилж, зөвлөлийн бүрэлдэхүүнд төрд татвар төлдөг, төрөөр үйлчлүүлдэг байгууллага, иргэний нийгэм, иргэдийн төлөөллийг тэнцвэртэй, өргөн хүрээтэй оролцуулж, нийгэм, олон нийтийн хяналтын механизмыг төлөвшүүлнэ.
- 1.16 Засгийн газрын дэргэд Хүний нөөцийн тусгай хороог байгуулж шилдэг мэргэшсэн боловсон хүчнийг төрд ажиллуулах, чадамж, бүтээлд суурилсан хүний нөөцийн сан бий болгоно.
- 1.17 Үндэсний аюулгүй байдал, хууль, хяналт, батлан хамгаалах салбар болон гадаад бодлого, стратегийн ач холбогдолтой ашигт малтмал, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх байгууллагуудын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтныг томилохдоо уг хүний нөөцийн санд бүртгэлтэй, мэргэшсэн боловсон хүчнээс зөвхөн сонгоно.
- 1.18 Төрийн албаны шалгалтыг боловсронгуй болгож, олон улсын жишгийн дагуу нийтлэг ерөнхий шалгалтаас гадна тухайн салбарын онцлогтой мэргэжлийн шалгалт авдаг болгоно.
- 1.19 Төрийн албанд гаднаас ажил үүрэг гэрээгээр гүйцэтгэх боломжийг нээж, үргүй зардал, орон тоог хэмнэх, төрийн албаны зарим салбарт ажлын цагийн уян хатан систем (Flexitime system) нэвтрүүлнэ.
- 1.20 Төрийн албанд ажиллагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор Төрийн албан хаагчдын холбоог шинээр байгуулна.
- 1.21 Сонгуулийн хуулинд төр ба ард түмний хооронд гэрээ байгуулах заалтыг нэмж оруулах замаар ард түмний хяналтыг тогтоож, хариуцлагатай улс төрийг бий болгоно.
- 1.22 Парламент бүрэн эрхийн хугацааны эхний хагаст багтаан Сонгуулийн хуулийг өөрчилж болох бөгөөд үүнийг үндэсний зөвшилцөлгүйгээр хийхийг хориглоно.
- 1.23 Оффшор банкинд данс, хадгаламжтай этгээдийг бүх шатны сонгуульд нэр дэвшүүлэх, төрийн албанд томилон ажлуулахаас татгалзана.
- 1.24 Парламентад суудалтай болон суудалгүй намуудын Улстөрийн байнгын зөвлөлийг парламентын дэргэд байгуулна.
- 1.25 Боловсролын салбарт улс төр, шашнаас хараат бус бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.26 Төрөөс улстөр-бизнесийн олигархи бүлэглэлийг зайлуулж, өөрсдөөр нь хүлээн зөвшөөрүүлж, ард түмнээс завшсан хөрөнгөө ядуурлыг бууруулах үйлсэд зориулахыг шаардана.
- 1.27 Цэрэг, цагдаа, тагнуулыг улс төрөөс хараат бус байлгаж, ард түмний эсрэг ашиглахыг хориглоно.
- 1.28 Үндсэн хуулинд нийтийн эрх, эрх чөлөөний тухай зүйлийг нэмэлтээр оруулна.

МОНГОЛ У
ҮНДЭСНИЙ АУДИ

УХА012

№ 16

16.04.2010 он

- 1.29 Гадны шашны гаж нөлөө, соёлын түрэмгийллээс үндэсний оюун санаа, үнэт зүйлс, соёлыг хамгаалах бодлого явуулна.
- 1.30 Үндэсний соёл, урлагаар дамжуулан үндэсний бахархлыг төлөвшүүлнэ.
- 1.31 Хэвлэл, мэдээллийн хэрэгслийг улс төр, эдийн засгийн бүлэглэлийн нөлөөнөөс ангижруулж, олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлнэ.
- 1.32 Шинжлэх ухааны салбарыг улс төрөөс хараат бус байх нөхцлийг бүрдүүлнэ.
- 1.33 Үзэл бодлоор ялгаварлах, хавчин гадуурхах, мөрдөн мөшгих ^{Заливаа} илрэлтэй хатуу тэмцэнэ.

2. ӨРГҮЙ МОНГОЛ

Хяналт, тооцоогүй гадаад, дотоод өр, өрийн сүлжээ, инфляцийн дарамт, дефляцийн аюул, төгрөгийн ханшны уналт, гадаад валютын ноёрхол, банкны зээлийн хүүгийн өсөлт, далд авилгалыг таслан зогсоож, тогтвортой төгрөг, тогтвортой эдийн засаг, тогтвортой үр дүн бүхий өргүй Монголоо байгуулна.

- 2.1 Үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийг санаатайгаар унагааж, санхүүгийн хямрал зохиомлоор үүсгэсэн бол үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт тооцож, хуулийн дээд хариуцлага ногдуулна.
- 2.2 Монголбанкны тогтолцоог Үндсэн хуулинд захируулан өөрчилж, ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахыг хатуу хориглоно.
- 2.3 Төлөх боломжгүй, өндөр хүүтэй мөнгө хүүлэх Монголбанкны бодлого, арилжааны банкны тогтолцоог засна.
- 2.4 Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дэргэд хараат бус Мөнгөний бодлогын хяналтын тусгай хороог байгуулж, мөнгөний бодлогын хэрэгжилт, мөнгөний нийлүүлэлт, бодлогын хүүгийн түвшин, своп хэлэлцээр, өрийн үзүүлэлт, зээлийн нөхцөлд хөндлөнгийн хяналт хэрэгжүүлнэ.
- 2.5 Төгрөгийн ханшны огцом уналтаас урьдчилан сэргийлэх, эрсдлээс иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг хамгаалах, хохирлыг хөнгөвчлөх хууль эрх зүй, даатгалын тогтолцоог бүрдүүлнэ.
- 2.6 Монгол Улсад зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр төлбөр, гүйлгээ гүйцэтгэж, зээл олгох бөгөөд гадаад валютын зээлийг үүрэг үүсэх үеийн ханшаар тооцох тухай Иргэний хуулийн 218.1 заалтыг заавал мөрдүүлэхийн төлөө тэмцэнэ.
- 2.7 Арилжааны банкууд дахь долларын зээлүүдийг зээлдэгчид болон банкинд алдагдалгүйгээр хуульд заасан ханшаар төгрөгийн зээл болгон шилжүүлэх санаачилгыг гаргана.
- 2.8 Төгрөгийн зээлийг валютын зээлд хувиргахыг хориглож, журмыг зөрчсөн банкыг зээлийн дүнгээр торгох, эрхийг хураах хүртэл арга хэмжээ авна.

- 2.9 Арилжааны банкны мөнгө хүүлэх хэт ашгийн төлөө үйл ажиллагааг таслан зогсоож, санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ, үр өгөөжтэй хамтын ажиллагаа, боломжит ашиг гэсэн эрх ашгийн эрэмбэ, зарчмаар ажиллуулна.
- 2.10 Өрийн менежментийг боловсронгуй болгож, өрийн тооцооллыг олон улсын стандартад нийцүүлж, Засгийн газрын өрийг давхар өрийн зээлээр төлөхийг хориглоно.
- 2.11 Монголбанк мөнгө, санхүү, татварын нэгдсэн уялдаатай бодлого хэрэгжүүлэх бөгөөд Засгийн газрын өрийг санхүүжүүлэх, мөнгө хэвлэж төсвийн алдагдал нөхөхийг хатуу хориглоно.
- 2.12 Засгийн газар Монголбанкны валютын нөөцөөс давсан гадаад өргүй байх зарчмыг тогтооно.
- 2.13 Эдийн засгийн хямрал, төсвийн алдагдалтай үед бүтээн байгуулалтын зээл авахыг хориглож, төсвийн орлогыг иргэддээ өндөр торгууль шийтгэл ногдуулах аргаар нөхдөг ёс суртахуунгүй бодлогыг хална.
- 2.14 Засгийн газрын өрийн бичгийн нийлүүлэлт, хүүгийн түвшинд тавих хөндлөнгийн хяналтыг сайжруулж, дээд хязгаар тогтооно.
- 2.15 Орлого, ашгаас нь үл хамаарсан татварын бодлого, тогтолцоог засч залруулна.
- 2.16 Эдийн засгийн хямралын үед зээлийн дарамт, ханшийн уналтад өртсөн жижиг, дунд үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд тодорхой хугацаагаар татвар, даатгалын шимтгэлийн "амралт" олгох хуулийг санаачилна.
- 2.17 Төсвийн хэмнэлтийн бодлого хэрэгжүүлж, бүтээснээсээ илүү хэрэглэхгүй байх зарчмыг баримтлана.
- 2.18 Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн зарлагыг УИХ-аас нэмэгдүүлэн батлахыг хориглоно.
- 2.19 УИХ-аас татварын хөнгөлөлтийн тухай хууль, Засгийн газраас татварын өршөөлийн хууль санаачлахыг хориглоно.
- 2.20 Төгрөгийн худалдан авах, хөрвөх чадварыг дээшлүүлэх, ханшийг чангаруулах бодлого барина.
- 2.21 Инфляцийн өсөлттэй уялдуулан цалин, тэтгэвэр, тэтгэмжийг тогтмол индексжүүлнэ.
- 2.22 Төрийн нэрээр авах гадаадын улс, олон улсын байгууллагын төслийн зээлийг түүний нөхцөл, үр өгөөжийг харгалзан шийдвэрлэх зарчимд шилжиж, бага хүүтэй, удаан хугацаатай, аливаа нөхцөл болзолгүй, зайлшгүй хэрэгцээт арилжааны зээлийг авахыг дэмжинэ.
- 2.23 Засгийн газрын тусгай сангуудын менежментийг төсөвт байгууллагаас тусгаарлаж, бие даалгах чиглэл барина.
- 2.24 Татвар төлөгчдийн мөнгийг үргүй зарцуулах, шамшигдуулахын эсрэг тэмцэж, ялын бодлогыг чангаруулна.

МОНГОЛ
ҮНДЭСНИЙ АУД

УХАО

№

20 16 он 04

3. АЮУЛГҮЙ МОНГОЛ

Үндэсний улс төр, эдийн засаг, нийгмийн аюулгүй байдлыг сахин хамгаалж, тусгаар тогтнолоо бэхжүүлж, монгол хүн, монголын ард түмний нэр төртэй, аюулгүй, баталгаатай, боловсролтой, эрүүл амьдрах орчныг бүрдүүлнэ.

УЛСЫН
ИТЭН ГАЗАР

А. Төрийн аюулгүй байдал, гадаад харилцаа, батлан хамгаалах бодлого

- 3.1 Төрийн бодлогод гадаад улс, хуулийн этгээд нөлөөлөх санаархал, оролдлогыг таслан зогсооно.
- 3.2 УИХ-аар хэлэлцэн дэмжигдээгүй, 2 удаа буцаагдсан хууль, тогтоолын төслийг тухайн парламентын бүрэн эрхийн хугацаанд дахин авч хэлэлцэхийг хориглоно.
- 3.3 Улсын нууцыг хамгаалах асуудлыг дээд төвшинд хүргэж, задруулсан, эх орноосоо урвасан этгээдэд хуулийн дээд цээрлэл үзүүлнэ.
- 3.4 Тэрроризмтай хатуу тэмцэж, түүний аливаа илрэлийг шийдвэртэй таслан зогсоож, олон улстай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
- 3.5 Ялын дээд хэмжээ цаазаар авах ялын түдгэлзлийг эрүүгийн нөхцөл байдал, олон нийтийн санаа бодлыг харгалзан дахин авч үзнэ.
- 3.6 Үндсэн хуулинд нийцээгүй олон улсын гэрээ, конвенцид нэгдэх, Монгол Улсад мөрдүүлэхийг хориглоно.
- 3.7 Үндэсний аюулгүй байдлын тогтолцоог шинэчлэн өргөжүүлж, бэхжүүлнэ.
- 3.8 Батлан хамгаалах бодлогыг улс төр, дипломатын аргаар бэхжүүлж, өөрийгөө хамгаалах цомхон, чадварлаг, мэргэжлийн арми, хил хамгаалах цэрэгтэй байхыг дэмжинэ.
- 3.9 Зөвхөн парламент зөвшөөрөн хууль баталснаар үндэсний армийг олон улсын энхийг сахиулах үйл ажиллагаа, дотоодын бүтээн байгуулалтад оролцуулахыг зөвшөөрнө.
- 3.10 Гадаад харилцааг улс төрийн болон эдийн засгийн дипломат бодлогыг хослуулан хөгжүүлнэ.
- 3.11 Хоёр хөрштэй тогтоосон найрсаг харилцаа, стратегийн түншлэлийг гүнзгийрүүлж, эдийн засгийн хамтын ажиллагааг төгөлдөржүүлнэ.
- 3.12 Дэлхийн улс орнуудтай эрх тэгш, нээлттэй, тэнцвэртэй харилцан хүндэтгэлтэй харилцааг тогтоож, бие биенийхээ дотоод хэрэгт үл оролцох зарчмыг мөрдөнө.

Б. Эдийн засгийн аюулгүй байдал, дэд бүтэц, үйлдвэржүүлэлт, уул уурхай, хотжилт

Эдийн засгийн бодлого

- 3.13 Дотоодын нийт бүтээгдэхүүний 4 ба түүнээс дээш хувийн мөнгөн урсгалтай бизнест төр оролцоно, 0,1-3 хувь бол зохицуулна, 0,1 хүртэлхид эс оролцоно гэсэн бодлого гаргана.
- 3.14 “Эдийн засаг, стратегийн ач холбогдолтой салбаруудад төрийн хяналт тогтоох тухай хууль” санаачлан батлуулж, өмнө хувьчлагдсан стратегийн ач холбогдолтой объектуудад төрийн хяналтыг тогтоож, үр ашгийг дээшлүүлнэ.
- 3.15 Архи, согтууруулах ундааны үйлдвэрлэлд төрийн монополь тогтоохыг дэмжинэ.
- 3.16 Монгол Улсын үндэсний нийт баялгийг үнэлж, эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцлийг бүрдүүлнэ.
- 3.17 Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинэчилж, хөрөнгө оруулалтын төрөл, хэлбэр, онцлог, хэмжээ, эдийн засгийн үр өгөөж, ашгийн урсгал, байршил, дахин хөрөнгө оруулалт, түүний өсөлт зэргийг харгалзан аливаа хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулахыг дэмжинэ.
- 3.18 Үндэсний хөрөнгө оруулагчдад ижил таатай нөхцөл олгож, тэднийг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглоно.
- 3.19 Үнэт цаасны зах зээлийн хөгжлийг гүнзгийрүүлж, Хөрөнгийн биржийн үйл ажиллагааг дэлхийн жишигт хүргэж, иргэд сонирхсон хувьцаагаа чөлөөтэй арилжих, эзэмших нөхцлийг бүрдүүлнэ.
- 3.20 Ипотекийн зээлийн хүртээмжийг өргөжүүлж, бага орлоготой иргэд, малчид, гадаадад ажилладаг иргэд, залуу гэр бүлийг хамруулахыг дэмжинэ.
- 3.21 Хөрөнгө оруулалтыг татах, менежментийг сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийн хувьчлалыг зохион байгуулна.
- 3.22 Импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд татварын хөнгөлөлт үзүүлэх, ижил төстэй барааны экспортыг татвараар хязгаарлах эрх зүйн орчныг бий болгоно.
- 3.23 Экспортыг дэмжиж, монгол бүтээгдэхүүн гадаадын зах зээлд нэвтрэх таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн гадаад харилцааг идэвхжүүлнэ.
- 3.24 Хоёр хөрштэй эдийн засгийн коридор байгуулах, гуравдагч орнуудын зах зээлд харилцан татваргүй бараа нийлүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.
- 3.25 Монгол Улсын стратегийн бараа бүтээгдэхүүний импортын үндсэн чиглэлийг шинэчилж, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний татварыг ялгавартай тогтоож, “Өдөр тутмын худалдан авалтын тухай хууль” санаачлан хэрэгжүүлнэ.
- 3.26 Орон нутагт жижиг дунд үйлдвэр, өрхийн үйлдвэрлэлийг тэлэх бодлого барьж, ЮМ БҮТЭЭХ орчин нөхцлийг бүрдүүлсэн, орон нутгийн

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТ

УХА0122

№ 783
2016 он 04 сар

идэвхи санаачилгад тулгуурласан тохилог, ухаалаг хот (compact city) болгож хөгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдүүлнэ.

- 3.27 Иргэдийн ахуй амьдралд зохицсон уян хатан санхүүгийн бичил үйлчилгээг нэвтрүүлж, ажилтай, орлоготой иргэдээ бодлогоор дэмжиж, чинээлэг дундаж давхаргыг бий болгохыг зорино.
- 3.28 Тогтвортой хөдөлмөр эрхлэлт, өрхийн бизнесийн санааг хөхиүлэн дэмжих, тэтгэх зорилгоор төрийн зарим тусгай сангуудыг нэгтгэж, зорилтот эх үүсвэрийг бий болгоно.
- 3.29 “Монгол иргэдийн амьжиргааны орчин нөхцлийг хамгаалах тухай хууль” боловсруулж батлуулна.
- 3.30 Үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүн худалдан авсан хэрэглэгчид татварын хөнгөлөлт үзүүлэх хууль санаачилна.

Уул уурхай

- 3.31 Ашигт малтмалын төрөл, ордын нөөцийг харгалзахгүйгээр байгалийн баялаг ард түмний өмч гэж үзэж, төр 51-ээс доошгүй хувийг эзэмших эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 3.32 Монголын уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн үнэлгээг сайжруулахад онцгой анхаарч, үнийн нэгдсэн бодлого зохицуулалт хийнэ.
- 3.33 Засгийн газарт мэдэгдэлгүйгээр олон улсын зах зээлд Монголын баялгийг барьцаалан хөрөнгө босгох, зөвшөөрөлгүйгээр эрх шилжүүлэх, худалдахыг хориглоно.
- 3.34 Үндэсний эрх ашигт харшилсан олон улсын гэрээ, хэлцлүүдийг дахин хянаж, хамтрагч этгээдтэй хэлэлцэн, засч залруулах, сайжруулах арга хэмжээ авна.
- 3.35 Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээг үндэсний эрх ашигт нийцүүлэн сайжруулах гарцыг олж, харилцан ашигтайгаар шийдвэрлэнэ.
- 3.36 Оюутолгой болон гадаад, дотоодын аж ахуйн нэгжүүдийн экспортын орлогыг Монголын банкаар заавал дамжуулах үүргийг журамлана.
- 3.37 Тавантолгойн ордыг ард түмний мэдэлд 100 хувь үлдээж, төслийг хэрэгжүүлэх эрхийг үндэсний хөрөнгө оруулагчдад давуу эрхээр олгох хуулийг санаачилна.
- 3.38 Улсын төсвийн хөрөнгөөр эрэл хайгуул хийсэн болон стратегийн орд газруудын хууль бусаар олгогдсон лицензийг цуцалж, буруутай этгээдүүдэд хариуцлага тооцуулна.
- 3.39 Нөөц нь тогтоогдсон ордуудыг дахин нягталж, стратегийн ордод хамруулах эсэхийг шийдвэрлэнэ.
- 3.40 Дархан цаазт газар, төрийн тусгай хамгаалалттай газар, хилийн бүс, төв суурин газарт болон Урт нэртэй хуулийг зөрчин олгосон

лицензүүдийг цуцалж, малчдын хаваржаа, өвөлжөө, оршуулгын газрыг тусгай зөвшөөрлөөс хэсэгчлэн чөлөөлүүлнэ.

3.41 Байгалийн баялгийг өвөг дээдсийн буян, өнөө бидний хишиг, үр хойчийн өмч хэмээн үзэж, Үндэсний ирээдүйн сангийн тухай хуулийг санаачлан батлуулна.

3.42 Үндэсний ирээдүйн санг бүрдүүлэх, хадгалах, захиран зарцуулах журмыг хуулиар зохицуулах бөгөөд улсын төсвийн санхүүжилтэд тус сангаас жил бүр 10 хүртэл хувиар зарцуулахыг зөвхөн УИХ хэлэлцэн шийдвэрлэнэ.

3.43 Ашигт малтмал олборлогч бүх аж ахуйн нэгж өмчийн хэлбэр харгалзахгүйгээр жил бүр Үндэсний нөөцийн санд уул уурхайн бүтээгдэхүүн борлуулсан ашгийн 10 хувийг төвлөрүүлэхээр хуульчилна.

МОНГОЛ УЛ
ҮНДЭСНИЙ АУДИТ

УХА012

№ 7
20 16 он 04 сар

Үйлдвэржүүлэлт

3.44 Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эдийн засгийн тэргүүлэх бодлогын хэмжээнд тавьж, эрчимжүүлж, өндөр технологи нэвтрүүлсэн боловсруулах үйлдвэр, экспортод чиглэсэн экологийн цэвэр хүнсний үйлдвэрлэл болгон хөгжүүлж, малчин өрхийн болон жижиг дунд үйлдвэрийг хөнгөлттэй зээл, санхүүгийн арга хэрэгсэл, урамшуулал, хаягласан төсөл, хөтөлбөрөөр тууштай дэмжинэ.

3.45 Үр тариа, хүнсний ногоогоор дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, экспортод чиглэсэн органик бүтээгдхүүний үйлдвэрлэлийг төрөөс дэмжинэ.

3.46 Экспортын чиг баримжаатай эрчим хүч, дулаан, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрийг хувийн хөрөнгө оруулалтаар байгуулахыг дэмжинэ.

3.47 Үндэсний үйлдвэрүүдийг сэргээх, хөгжүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, уул уурхайн түүхий эдэд түшиглэсэн хүнд үйлдвэрийн суурийг тавина.

3.48 Газрын тос, кокс боловсруулах үйлдвэрүүдийг үндэсний болон гадаадын хөрөнгө оруулалтаар байгуулж, түүнийг түшиглэн нефть, кокс химийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

3.49 Зэс, төмөр, газрын ховор элемент, бусад металлын хүдэр боловсруулах үйлдвэрийг хувийн хэвшлийн хөрөнгөөр байгуулахыг татвар, зээлийн бодлогоор дэмжиж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилтыг хэрэгжүүлнэ.

3.50 Жижиг, дунд үйлдвэрлэл, бизнесийн бүртгэл, тусгай зөвшөөрлийг хялбарчилж, татвар, зээлийн бодлогоор туслан дэмжиж, тоног төхөөрөмж, шинэ технологийг лизинг, франчайз, хөнгөлттэй үнээр нийлүүлдэг таатай орчин бүрдүүлнэ.

Хотжилт

- 3.51 Нийслэл Улаанбаатар хотын төлөвлөлтийг шинэчилж, эрх зүйн таатай нөхцөлтэй дагуул хотуудаар тэлэх бодлого баримтлана. **ЫН ГАЗАР**
- 3.52 Улаанбаатар, Дархан, Эрдэнэтээс гадна баруун бүсэд Хархорин, Ховд, зүүн бүсэд Өндөрхаан, говийн бүсэд Даланзадгад гэсэн үндэсний статустай хотуудыг байгуулж, хөнгөн, хүнд үйлдвэр, шинжлэх ухаан-технологи, үйлдвэр-сургалтын төв, аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 3.53 Хүн амын тоо, эдийн засгийн чадавхи, дэд бүтцийн хөгжил, газар зүйн байршил, үндэсний аюулгүй байдалд үзүүлэх нөлөө зэрэг хүчин зүйлийг харгалзан засаг захиргааны нэгжийн өөрчлөлтийг эхлүүлж, аймгийн төвүүдийг бүсийн статустай хотын бодлогоор хөгжүүлнэ.
- 3.54 Аялал зуучлалын үндэсний хөгжлийн хөтөлбөр, үндэсний сүлжээ байгуулж, аялал жуулчлалын тусгай бүс, цогцолбор газруудыг хөгжүүлнэ.

Дэд бүтэц

- 3.55 Хэвтээ тэнхлэгийн төмөр замыг барьж эхлэх бодлогыг гаргана.
- 3.56 Улаанбаатар хотыг тойруулан 2 урсгалтай төмөр зам барих төслийг эхлүүлнэ.
- 3.57 Евроазийг холбох “Талын зам” стратегийн хурдны замын төслийг эхлүүлж, олон улсын стандартад нийцсэн тээвэр ложистикийг хөгжүүлнэ.
- 3.58 Улаанбаатар хотын авто замыг бүрэн шинэчилж, замын ачааллыг бууруулахад гүүр, давхар гүүрэн болон нүхэн зам, гарц барих төслүүдийг концессоор шийдвэрлэхийг дэмжинэ.
- 3.59 Нийслэл, аймаг, сум, суурин газрын гэр хорооллын дэд бүтцийг хөгжүүлнэ.
- 3.60 Хот, суурин газрын нийтийн тээврийн асуудлыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар бүрэн шийдвэрлэнэ.
- 3.61 Шинээр баригдах хорооллуудад нийгмийн дэд бүтцийг заавал төлөвлөх стандарт тогтоож, өмнө ашиглалтад орсон хорооллуудад дахин төлөвлөлт хийж, алдааг залруулна.
- 3.62 Гэр хорооллын дахин төлөвлөлтийг иргэдийн эрх ашигт нийцүүлэн үргэлжлүүлж, эрсдлээс хамгаалах төрийн баталгааны тогтолцоо бүрдүүлнэ.

В. Нийгмийн аюулгүй байдал, боловсрол, эрүүл мэнд, байгаль орчин

Боловсрол

- 3.63 Үндэсний онцлогтой ерөнхий боловсролыг төрөөс онцгойлон анхаарч, сургалтын агуулга, арга зүй, сурах бичгийн агуулгад улсын хэмжээгээр нэгдсэн судалгаа хийж, дүгнэлтийг УИХ-аар хэлэлцүүлж, нэгдсэн стандарт тогтооно.
- 3.64 Улсын нэгдсэн төвшин тогтоох шалгалтыг жил бүр, тусгайлан 10 ба 15 настнуудын дунд эх хэл, түүх, байгалийн шинжлэл, гадаад хэлний хичээлээр улс орон даяар нэгдсэн байдлаар явуулж сурлагын төвшин тогтоож байна.
- 3.65 Бага, дунд ангийн анги дүүргэлтийг 30-аас доошгүй хүүхэдтэй байхаар төлөвлөнө.
- 3.66 Аймаг, дүүргүүд өөрийн хөрөнгө хүч, төсөв, санхүүгийн боломжоор сургууль байгуулж болох хууль эрх зүйн боломжийг бүрдүүлнэ.
- 3.67 Хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургуулиудын төлбөрийг бодитой тогтооход анхаарч, боловсролоор бизнес хийх, ашиг олохын эсрэг байна.
- 3.68 Ирээдүйд ясль, цэцэрлэг, бага сургууль, төрөх эмнэлгүүдийг төлбөргүй болгохыг дэмжиж ажиллана.
- 3.69 Ясль, цэцэрлэгүүдийг хувьчлан авч, үйл ажиллагааг нь өөрчилж хувьдаа завшсан хувь хүмүүс, компаниас нийтийн сайн сайхны төлөө холбогдох хуулийн хүрээнд нөхөн төлбөр авах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
- 3.70 Их, дээд боловсролын тогтолцоог дэлхийн жишигт хүргэх, өрсөлдөх чадвартай болгох бодлогыг хэрэгжүүлнэ.
- 3.71 Их, дээд сургуулиудын хүний нөөц, багшлах боловсон хүчний сонгон шалгаруулалтыг ил тод болгож, дэлхийн топ 100 сургуульд магистр, докторын зэрэг хамгаалсан залуу эрдэмтэн, судлаачдыг өргөнөөр ажиллуулна.
- 3.72 Их, дээд сургуулиудыг дэлхийн болон Азийн шилдэг их сургуулиудын салбар сургуультай болгох, өргөтгөх бодлогыг түлхүү анхаарна.
- 3.73 Мэргэжлийн боловсролын сургуулиудыг өргөтгөх, бааз суурийг бэхжүүлэх, дэмжих замаар зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үндэсний мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэнэ.
- 3.74 Албан бус сургалт, зайн сургалт, түр сургалтын хэлбэрүүдийг зэрэгцүүлэн хөгжүүлнэ.
- 3.75 Фермерийн болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн мэргэжлээр суралцаж буй малчин өрхийн нэг хүүхдийн сургалтын зардлыг төр хариуцах тухай хууль санаачилна.
- 3.76 Шинжлэх ухааны үнэлэмжийг дээшлүүлж, шинэ нээлт, бүтээлийг урамшуулж, амьдралд нэвтрүүлэхэд төрөөс дэмжинэ.

Эрүүл мэнд

МОНГОЛ УЛС
ҮНДЭСНИЙ АУДИТ

УХА0122

№ 78

20 16 он 04 сар

- 3.77 Эрүүл монгол хүн төслийг 4 жил тутам хэрэгжүүлнэ.
- 3.78 Байгалийн гаралтай, органик монгол эмийн үйлдвэрлэлийг дэмжинэ.
- 3.79 Нийслэл болон улсын статустай хот, аймгийн төвүүдэд орчин үеийн эмчилгээ оношлогооны төв шат дараатай байгуулах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 3.80 Өмчийн хэлбэрээс үл харгалзан эмнэлгүүдэд Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт олгохоор журамлана.
- 3.81 Өндөр өртөгтэй эмчилгээ, нөхөн сэргээлт, эмийн зардлын хөнгөлөлтийг төрөөс үзүүлж, хувийн болон улсын эрүүл мэндийн даатгалд хамруулахыг дэмжинэ.
- 3.82 Эрүүл мэндийн салбарт оруулсан хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын татварыг хөнгөлөх төрийн бодлого хэрэгжүүлнэ.

Байгаль орчин

- 3.83 Сэргээгдэх эрчим хүч, нар, салхины эрчим хүч ашиглах, хүлэмжийн хий багасгах чиглэлээр Монгол Улсын хэмжээнд баримталж байгаа хууль, олон улсын гэрээ, конвенцийн заалтыг хэрэгжүүлж ажиллана.
- 3.84 Азийн орнуудыг монголын говийн нар, салхины эрчим хүч ашиглаж эрчим хүчээр хангах мега төсөлд Монгол Улс идэвхитэй тоглогч байх төрийн бодлогыг эрчимжүүлнэ.
- 3.85 Нар, салхи зэрэг байгалийн нөхөн сэргээгдэх эрчим хүчийг ашиглахыг төрөөс онцгойлон дэмжинэ.
- 3.86 Усан цахилгаан станц байгуулах асуудалд хүрээлэн буй байгаль орчны тэнцвэрийг алдагдуулахгүй байх үндсэн зарчмыг баримтлана.
- 3.87 Монгол Улсад АЦС байгуулах асуудлаар нийт ард иргэдийн санал асуулга явуулна.
- 3.88 Цөмийн хаягдал булшлах аливаа санаархлыг таслан зогсоож, хуулийн хorigийг боловсронгуй болгоно.
- 3.89 Үйлдвэрлэлийн зориулалтаар гүний ус ашиглахад хяналт тогтооно.
- 3.90 Ой, усны нөөц ашигласны төлбөрийг нэмэгдүүлж, тэдгээрийг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулна.
- 3.91 Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хүн ам төвлөрсөн хот суурин газруудад шийдвэрлэж, төрөөс татвар, зээлийн бодлогоор дэмжинэ.
- 3.92 Ой, рашаан булаг хамгаалсан, өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, хуулийн этгээдийг төрөөс урамшуулах журам гаргана.
- 3.93 Нэн ховордсон ан амьтныг хамгаалах, ургамлыг нөхөн сэргээх тэдгээрийг дахин нутагшуулах эрх зүй, эдийн засгийн үндсийг бүрдүүлнэ.
- 3.94 Цөлжилт, хөрсний эвдрэл, түйрэн, элсний нүүдэлтэй тэмцэх зорилгоор ойг нөхөн сэргээх, говь, хээрийн бүсэд ногоон зурвас байгуулна.

3.95 Хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх арга технологиор ашигт малтмал олборлох, уул уурхайн үйлдвэрлэл явуулахыг хуулиар хориглоно.

3.96 Агаар, хөрсний бохирдолтой тэмцэх оновчтой арга, технологи нэвтрүүлж, төрөөс санхүүгийн дэмжлэг, урамшуулал олгохыг дэмжинэ.

3.97 Иргэдийн эрүүл аюулгүй орчин, хүнсний аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор гаалийн болон мэргэжлийн хяналтын лабораторын хүчин чадлыг нэмэгдүүлж, хүнс болон байгаль орчны хяналт шинжилгээг сайжруулна.

МОНГОЛ УЛС
ҮНДЭСНИЙ АУДИТЫ

УХА0122

№ 78
2016 он 04 сар

4. ЭРСДЭЛГҮЙ МОНГОЛ

Халамжийн оновчтой, даатгалын хүртээмжтэй, хөдөлмөр эрхлэлтийн хүчтэй бодлого явуулж, ард иргэдээ болзошгүй эрсдлээс хамгаална.

Нийгмийн халамж

- 4.1 Нийгмийн халамжийг зөвхөн хөдөлмөр эрхлэх чадваргүй эмзэг хэсэг, зорилтот бүлэгт чиглүүлж, төвлөрлийг сааруулах бодлогоор орон нутагт эрх мэдэл, Нийгмийн халамжийн сангийн менежментийг бүрэн шилжүүлнэ.
- 4.2 Төрөлт буурч, гэр бүл салалт өсч, хүүхдийн хөгжил саатаж буй сөрөг үзэгдлийг бууруулах зорилгоор нярай эх, бага, дунд боловсролтой эмэгтэйчүүд, нэн ядуу өрхийн болон гадаадад ажиллаж байгаа иргэдийн хүүхдүүдэд чиглэсэн улс төрийн шийдэлтэй тодорхой нийгмийн хамгааллын бодлогыг дэвшүүлнэ.
- 4.3 Хүүхэд төрөх, эрүүл саруул өсч торних, амар тайван амьдралыг хангахад чиглэсэн нийгмийн хамгаалал, даатгалын зөв орчныг бүрдүүлнэ.
- 4.4 Залуу гэр бүлд зориулсан тусгай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 4.5 Ахмад настны нийгэм хамгааллын зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагууд болон хувийн хэвшлийнхнээр гүйцэтгүүлж байх хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 4.6 Нийгмийн халамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн зардлын хоёрны нэгийг улсаас, дөрөвний нэгийг тухайн орон нутгийн төсвөөс, үлдсэн хэсгийг буюу үүсгэн байгуулагчийн гаргах хэсгийг зээл хөрөнгө оруулалтын механизмаар зохицуулдаг гадаадын туршлагыг хуульчилна.
- 4.7 “Монгол хүний амьжиргаа хамгаалал, баталгааны тухай хууль” санаачилж, хүний амьжиргаа хамгааллын тусгай төсөв бий болгохын төлөө ажиллана.
- 4.8 Өрхийн сарын орлого нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хүрэхгүй бол зөрүүг уг төсвөөс олгох хуулийг санаачилна.
- 4.9 Жилд тэрбумаас дээш орлоготой чинээлэг иргэдээс нийгмийн халамжийн төрийн бодлогыг дэмжих тусгай татвар авах хуулийн орчин бүрдүүлнэ.

Нийгмийн даатгал

- 4.10 Нийгмийн даатгалын хэлбэр төрлийг нэмэгдүүлнэ.
- 4.11 Нийгмийн даатгалын хөрөнгийг төсвийн санхүүжилтэд ашиглахыг хориглож, менежментийг бие даасан, хараат бусаар явуулах нөхцлийг бүрдүүлнэ.
- 4.12 Эрүүл мэндийн даатгалыг бие даасан тогтолцоонд шилжүүлнэ.
- 4.13 Давхар даатгалын тогтолцоог нэвтрүүлнэ.
- 4.14 Гадаадад ажиллаж, амьдардаг болон хүндэтгэх шалтгаантай иргэдэд нийгмийн даатгалаа нөхөн төлөх эрх зүйн боломжийг нээнэ.
- 4.15 Өндөр зардалтай эмчилгээг эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулж, нөхөн төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэхээр ажиллана.
- 4.16 Нийгмийн даатгал нь тасарсан иргэдэд дахин нэг удаа нөхөн төлөх боломж олгох хуулийг санаачилна.
- 4.17 Чинээлэг хувь хүн өндөр шимтгэл төлөөд өндөр зэрэглэлийн тусгай тэтгэвэрт хамрагдаж болох хуулийн орчныг бүрдүүлнэ.
- 4.18 “Хөдөлмөр эрхлэлтийн даатгалын тусгай сангийн тухай хууль” санаачилж, хууль бусаар ажлаасаа халагдсан нь тогтоогдсон бол ажил олгогч хамгийн өндөр цалингийнх нь хэмжээг 100% олгох, уг сангаас даатгалын шимтгэл төлсөн дүнгийн тодорхой хувиар ажилгүйдлийн тэтгэмж дээр нэмж олгож байхаар зохицуулна.

Хөдөлмөр эрхлэлт

- 4.19 Хөдөлмөрийн насны буюу эдийн засгийн идэвхтэй хүн амын хөдөлмөрлөх эрхийг баталгаажуулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогоор идэвхжүүлж, зайлшгүй хөдөлмөрлөх нөхцөл, боломжоор хангана.
- 4.20 Нэн ядуу хөдөлмөрийн насны иргэдийн ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг төр хариуцаж, ажилгүйдлийн даатгалын санг бүрэн бүрдүүлэх замаар ажилгүй иргэдийг ажилтай болох хугацааны тэтгэмж олгодог чадавхийг бий болгоно.
- 4.21 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

5. АВИЛГАГҮЙ МОНГОЛ

Авилгыг устгах, шударга ёсыг хамгаалах бодлогыг үндсэн зарчмаа болгоно.

- 5.1 Авилгын хэргийг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдал, учруулсан хор уршиг, хохирлын хэмжээг харгалзан ялын ялгавартай бодлого баримтлана.
- 5.2 Авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авилгыг үл тэвчих орчныг бүрдүүлнэ.
- 5.3 Хууль, хяналтын байгууллагын эрх зүйн байдал, тогтолцооны шинэчлэлийг гүнзгийрүүлнэ.

- 5.4 Төрийн албаны ашиг сонирхлын зөрчилтэй хатуу тэмцэж, хариуцлагыг чангаруулна.
- 5.5 Үзэл суртлын агуулгатай, авилгын шинжтэй төрийн шагналын системийг халж, алдаршуулах, урамшуулах бодлого дэвшүүлнэ.
- 5.6 Ардчилсан орнуудын засгийн газрууд, олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажиллаж гадаад дотоодод байгаа олигархиудын үл хөдлөх хөрөнгө, хувьцаа болон хадгаламжийг олон нийтэд ил тод болгоно.

№ 788
2016 он сар өдөр

6. МЭДЛЭГТ ТУЛГУУРЛАСАН НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ

Байнга хувьсан өөрчлөгдөж, эрчимтэй хөгжиж буй дэлхий ертөнцөд үнэ цэнэтэй тоглогч, хүчтэй өрсөлдөгч байхын тулд цаг алдахгүй мэдлэгт тулгуурласан нээлттэй нийгмийг зорих болно.

- 6.1 Улс төр, эдийн засаг, нийгмийн бүх хүрээнд Монгол үндэстнийг мэдлэгт тулгуурласан нийгэмд шилжүүлэх үндэстний хөдөлгөөнийг бүх орон даяар төлөвлөгөөтэй хэрэгжүүлнэ.
- 6.2 Шинжлэх ухааны судалгааны тэргүүлэх чиглэлийг дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, улс орны зорилттой уялдуулан тодорхойлж, хэрэгжих баталгаагаар хангана.
- 6.3 Төрийн бодлого төлөвлөлт, шийдвэр гаргах үйл ажиллагаа, хэрэгжүүлэлтийг шинжлэх ухаан, шинэ мэдлэг, шилдэг менежментээр хөтөлнө.
- 6.4 Шинжлэх ухааны академи, их, дээд сургуулиудын судалгаа, шинжилгээний чадавхийг төвлөрүүлж, шинжлэх ухаан-сургалт-үйлдвэрлэлийн нэгдлийг үүсгэн инновацийг амилуулах, нутагшуулах гарааны (start up) компаниудыг байгуулж, бизнес инкубатор төвүүдэд бойжуулна.
- 6.5 Шинжлэх ухааны академийн оролцоотойгоор инновацийг нэвтрүүлэх, өндөр технологи нутагшуулах Үндэсний техник технологийн парк, цахим программ үйлдвэрлэх Үндэсний мэдээллийн технологийн парк гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар байгуулах эрх зүйн орчныг төгөлдөржүүлж, хэрэгжилтийг хангахаар ажиллана.
- 6.6 Улаанбаатарт олон улсын жишигт хүрсэн үндэсний нанотехнологи, биотехнологийн лаборатор байгуулах асуудлыг дэмжинэ.
- 6.7 Хиймэл оюун ухааны үйлдвэрлэлийг салбарын хэмжээнд хөгжүүлж, төрөөс дэмжинэ.
- 6.8 Өндөр технологийн судалгаа, шинжилгээг төрөөс бүрэн санхүүжүүлэх бодлого дэвшүүлнэ.
- 6.9 Шинжлэх ухааны нээлт, бүтээл, инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, судалгаа шинжилгээг гүнзгийрүүлэх, оюуны чадавхийг төвлөрүүлэх, шинэ залуу боловсон хүчнийг бэлтгэх, үндэсний чадварлаг компани, шилдэг брэндийг төрүүлэх зорилгоор Мянгат сити хотхон байгуулах эхлэлийг тавина.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2016.04.29 № 483

танай _____ -ны № _____ -т

Нийцлийн талаарх дүгнэлт

Монгол Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлэх хүсэлт гаргаж байгаа Эх орончдын нэгдсэн эвсэл /Эх орончдын нэгдсэн нам-Хамуг Монголын хөдөлмөрийн нам/-ийн "Сонгуулийн мөрийн хөтөлбөр"-т Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хянаж дүгнэлт гаргав.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Сонгуулийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг Төрийн аудитын байгууллагад ирүүлж Сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах хариуцлага хүлээнэ.

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.17-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд эвслийн боловсруулсан сонгуулийн мөрийн хөтөлбөр Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуультай нийцэж буй эсэх талаарх дүгнэлтийг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д заасан хугацаанд Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх үүрэгтэй.

Дүгнэлтийн үндэслэл

Үндэсний аудитын газар УИХ-ын ээлжит сонгуульд оролцох Эх орончдын нэгдсэн эвслээс ирүүлсэн "Сонгуулийн мөрийн хөтөлбөр"-ийг Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт-4000, Төрийн хяналт шалгалтын стандартыг удирдлага болгон Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нийцүүлэн дүгнэлт гаргав.

Дүгнэлт

Эх орончдын нэгдсэн эвслийн Сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуультай нийцсэн болно.

Хувийг: Эх орончдын нэгдсэн эвсэлд

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2016\0425\NAC\00\Doc2

000036